Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 7 хоногийн тайлан
/2019.08.19-2019.08.23/

2019.08.23 Дархан хот

№	Ажлын чиглэл	Гүйцэтгэлийн үр дүн
		Барилга хот байгуулалтын хэлтэс
1	Зураг төсөл, магадлал	- Дархан сум, 4-р багт байршилтай дахин төлөвлөлтийн загвар зургийг судлаж, ерөнхий архитекторт танилцуулсан. - Татварын алба болон Дархан сумын 14-р багийн өрхийн эмнэлгийн барилга барих газрын байршлын судалгааг хийлээ. - Архитектур төлөвлөлтийн даалгавар гаргуулах хүсэлтийн дагуу 2 ААН, иргэнд хүсэлтийн дагуу архитектур төлөвлөлтийн даалгаврыг гүйцэтгэсэн. - Техникийн нөхцөл тодруулах хүсэлттэй 4 иргэнд дулааны тодруулах олгосон.
2	Барилгын материал үйлдвэрлэл	- Онцгой байдлын газартай хамтран 2019.08.19-ны өдөр Гялалзах гэрэл ХХК-ын барилгын материал /ган бөмбөлөг/ үйлдвэрлэж буй үйл явц, үйлдвэрлэлийг технологийн горимын дагуу явагдаж буй эсэхтэй танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Үйлдвэрлэлийн үйл явцтай танилцахад үйлдвэрийн байр нь халуун, хортой нөхцөлтэй бөгөөд ажлын байрны шаардлага хангахааргүй, ажилчид нь малгай, маск гэх мэт хөдөлмөр хамгаалалтын хувцасгүй ажиллаж байв. Шалгалтын мөрөөр хөдөлмөрийн нөхцөлийг хангах тухай хугацаатай шаардах бичиг хүргүүлээд байна. - 2005-2019 оны ашиглалтанд хүлээлгэн өгсөн 223 барилга байгууламжийн хувийн хэргийн 90 баримт бичгээр меморалдаж, архивт хүлээлгэн өгөхөд бэлтгэж үдэв, мөн 30530 хуудас цахим архив үүсгэсэн. Гүйцэтгэл 95 %
		Газрын удирдлагын хэлтэс
3	Газар зохион байгуулалтын төлөвлөлт, өмчлөл	- Газар зохион байгуулагч нар энэ долоо хоногт Улсын бүртгэлийн хэлтэст нийт 2+ иргэн, хуулийн этгээдийн Е-дугаар авах хүсэлтийг илгээж, 1+ иргэн, ААН байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ, гэрээ байгуулж ажилласан байна. - Оросын холбооны улсын өмчлөлд байгаа үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээтэй 12 байршилд газар ашиглуулах захирамжийн төслийг бэлтгээд байна. - 71 иргэн, хуулийн этгээдийн нэгж талбарын хувийн хэргийг хөтлөж, газрын төлбөрийн мэдээллийн санд бүртгэлээ.
4	Газрын төлбөр	- 2019.08.23-ний өдрийн байдлаар 437.6 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний хэрэгжилт 58.7 хувьтай байна.
		Захиргаа аж ахуйн хэлтэс
5	Дотоод ажил	**Мэдээлэл:** - Ашиг сонирхлын зөрчилгүй илэрхийлсэн 20 мэдэгдэл тайлбарыг Авлигатай тэмцэх газрын цахим бүртгэлийн системд оруулсан. **Нярав:** - Нэгж талбарын хувийн хэрэг 34 ширхэгийг нугалж бэлтгэв.

		- Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 110 ш кадастрын цаас, 16 ш НТХХ, 18 ш газар эзэмших гэрчилгээ /Иргэн/, 3 ш газар эзэмших гэрчилгээ /ААНБ/-ний үнэт цаас олгов. - Шаардах хуудсаар 2 төрлийн 11 ширхэг бараа материал олгогджээ. **Мэдээлэл технологи:** - 70376471 нээлттэй утсаар нийт 5 иргэний асуултанд хариулт өгөв. - Хуваарийн дагуу серверийн өрөө, өрөөний агааржуулагчийг цэвэрлэв. - Байгууллагын цахим хуудас болон Facebook хуудсан дээр Хойд бүсийн аварга шалгаруулах "Өрөг угсрагч", "Шавардлага"-ын ажил мэргэжлийн уралдааны зар, “15000 айлын-Орон сууц” үндэсний хөтөлбөрийн талаарх мэдээллийг байрлуулав. - Байгууллагын цахим хуудас дахь мэдээллүүд устсан тул мэдээллийг нөхөн оруулах зорилгоор байгууллагын цахим хуудсан дээр “Хууль, эрх зүй” цэсэнд байрлах Салбарын хуулиуд, УИХ-ын тогтоолууд, ЗГ-ийн тогтоолууд, Сайдын тушаалыг байрлуулах кодыг HTML хэл дээр бичиж нөхөн байрлуулав. - Мөн газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр гаргасан ГЗБГЗЗГ-ын даргын тушаал болон Барилга, хот байгуулалтын сайдын тушаалын URL хаягийг олж, хавтас үүсгэн, цахим хуудсанд байрлуулах кодыг HTML хэл дээр бичиж нөхөн байрлуулав. **Архив, бичиг хэрэг:** - Газрын эрхийн хугацаа сунгасан, талбай өөрчлөгдсөн, эрх шилжүүлсэн, шинээр олгогдсон нийт 71 нэгж талбарын хувийн хэргийг хүлээн авч, мэдээллийн санд бүртгэн, архивт хүлээн авлаа. Энэ долоо хоногт тус байгууллага нь 16 өргөдөл /138 хуудас/, 27 албан бичиг /97 хуудас/ хүлээн авч, 15 албан бичиг /41 хуудас/ явуулсан байна.

Тайлан нэгтгэсэн: Ц.Цэнд-Аюуш

Хянасан:

ГУХ-ийн дарга Г.Нямдорж